



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

211.	Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 50	565
212.	Улсын дээд шүүхийн танхимын тэргүүнийг томилох тухай	Дугаар 51	566
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ			
213.	Жагсаалт батлах тухай	Дугаар 42	566
214.	Тооны дээд хязгаар, мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай	Дугаар 51	578
215.	Биеийн тамир, спортын хөгжлийн төв байгуулах тухай	Дугаар 56	580

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 03 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн тул Бандийн Одонцэцэгийг Сум дундын 22 дугаар шүүхийн шүүгчийн, Пүрэвийн Лагчааг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 5 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсөнд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 03 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

Улсын дээд шүүхийн танхимын тэргүүнийг томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тогтохын Уранцэцэгийг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүнээр, Хээмчигийн Сонинбаярыг Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүнээр тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 2 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Худалдан авах ажиллагааны газраас 2015 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг 1 дүгээр, Хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж хэрэгжүүлэхийг Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Энхжаргалд, холбогдох зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг хуулийн хугацаанд Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай.



3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхэд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

Засгийн газрын 2015 оны 42 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРААС 2015 ОНД
УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

(сая төгрөгөөр)

	Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
	IV	БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД			1,500.0	500.0
	IV.1	I. Хөрөнгө оруулалт			1,500.0	500.0
		Шилжих			1,500.0	500.0
1	IV.1.1	Хот, суурин газрын ус хангамж, гидрогеологийн зураглалын судалгаа (Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь)	2012	2016	1,500.0	500.0
	V	ГАДААД ХЭРГИЙН САЙД			2,500.0	2,500.0
	V.1.3	III. Тоног төхөөрөмж			2,500.0	2,500.0
		Шинэ			2,500.0	2,500.0



2	Y1.3.1	АСЕМ-ын чуулга уулзалтыг зохион байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж	2015	2015	2,500.0	2,500.0
	Y1	САНГИЙН САЙД			1,380.0	380.0
	Y1.2	Гаалийн ерөнхий газар			1,380.0	380.0
	Y1.2.1	I. Хөрөнгө оруулалт			1,380.0	380.0
		Шилжих			1,380.0	380.0
3	Y1.2.1.1	Гаалийн боомтуудын холбоожуулалт	2013	2015	900.0	300.0
4	Y1.2.1.2	Гаалийн албаны мэдээллийн системийг бэхжүүлэх	2013	2015	480.0	80.0
	IX	БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД			20,355.1	19,999.2
	IX.1	Боловсрол			17,837.1	17,481.2
	IX.1.1	I. Хөрөнгө оруулалт			17,837.1	17,481.2
		Шинэ			17,837.1	17,481.2
5	IX.1.1.138	Цэцэрлэгийн барилгын давхрын өргөтгөл, нийт 6 цэцэрлэг (Улаанбаатар)	2015	2015	3,000.0	3,000.0
6	IX.1.1.139	Цэцэрлэгийн барилга (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 8 дугаар хороо)	2015	2015	950.0	950.0
7	IX.1.1.140	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, (Улаанбаатар, Баянгол дүүрэг, 95 дугаар цэцэрлэг)	2015	2015	880.0	880.0



8	IX.1.1.141	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл (Улаанбаатар, Баянгол дүүрэг, 120 дугаар цэцэрлэг)	2015	2015	880.0	880.0
9	IX.1.1.142	Цэцэрлэгийн барилга (150 ортой), (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 16 дугаар хороо)	2015	2016	1,200.0	150.0
10	IX.1.1.143	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл (Улаанбаатар, Баянгол дүүрэг, 13 дугаар хороо, 77 дугаар цэцэрлэг)	2015	2015	880.0	880.0
11	IX.1.1.144	Цэцэрлэгийн барилга худалдаж авах (Ховд, Жаргалант сум)	2015	2015	300.0	300.0
12	IX.1.1.145	Цэцэрлэгийн барилга худалдаж авах (200 ортой), (Баянхонгор, Баянхонгор сум, 10 дугаар цэцэрлэг)	2015	2015	1,606.4	1,606.4
13	IX.1.1.149	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл (Өвөрхангай, Хужирт сум)	2015	2015	850.0	850.0
14	IX.1.1.150	Цэцэрлэгийн барилга (100 ортой), (Дархан-Уул, Дархан сум, 15 дугаар баг, Хабитат хороолол)	2015	2015	1,250.0	1,250.0
15	IX.1.1.151	960 суудалтай сургуулийн спорт заалын барилга, сургуулийн гаднах ариутгах татуурга (Дундговь, Сайнцагаан сум)	2015	2015	942.8	942.8



16	IX.1.1.152	Сургуулийн барилгын өргөтгөл (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 84 дүгээр сургууль)	2015	2015	1,300.0	1,300.0
17	IX.1.1.153	Сургуулийн барилгын өргөтгөл (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 48 дугаар сургууль)	2015	2015	1,400.0	1,400.0
18	IX.1.1.154	Сургуулийн дотуур байрны барилга (150 ортой), (Баян-Өлгий, Алтай сум)	2015	2016	1,417.9	917.0
19	IX.1.1.156	Сургуулийн дотуур байрны барилга (100 ортой), (Баян-Өлгий, Сагсай сум)	2015	2015	980.0	980.0
	IX.2	Соёл			2,518.0	2,518.0
	IX.2.1	I. Хөрөнгө оруулалт			2,518.0	2,518.0
		Шинэ			2,518.0	2,518.0
20	IX.2.1.30	Соёлын төвийн барилга (Увс, Тэс сум)	2015	2015	1,518.0	1,518.0
21	IX.2.1.31	Соёлын төвийн барилга (Төв, Баянцагаан сум)	2015	2015	1,000.0	1,000.0
	X	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД			97,511.2	1,100.0
	X.1.1	I. Хөрөнгө оруулалт			97,511.2	1,100.0
		Шилжих			97,511.2	1,100.0



22	X.1.1.1	Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам төсөл"-ийн Өлгий-Ховд чиглэлийн авто замын үргэлжлэл хатуу хучилттай авто зам, 189.7 км (Ховд)	2014	2016	96,311.2	500.0
23	X.1.1.21	Шивэрийн голын төмөр бетон гүүр (Увс, Ховд сум)	2012	2016	1,200.0	600.0
	XII	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД			2,000.0	2,000.0
	XII.1	I. Хөрөнгө оруулалт			2,000.0	2,000.0
		Шинэ			2,000.0	2,000.0
24	XII.1.10	Хаалттай хуваарилах байгууламж 7-гийн өргөтгөл, 2 дугаар үе шатны ажил (Улаанбаатар)	2015	2015	1,800.0	1,800.0
25	XII.1.12	Цахилгаан хангамжийн 15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 15/0.4 кВ-ын хүчдэл 100 кВА-ын хүчин чадалтай агаарын дэд станц (Баянхонгор, Галуут сум, Мандал баг)	2015	2015	200.0	200.0
	XIII	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД			5,030.0	1,280.0
	XIII.1	I. Хөрөнгө оруулалт			5,000.0	1,250.0
		Шилжих			5,000.0	1,250.0



26	XIII.1.3	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж (Ховд)	2012	2016	5,000.0	1,250.0
	XIII.2	II. Их засвар			30.0	30.0
		Шинэ			30.0	30.0
27	XIII.2.1	Мал эмнэлгийн лабораторийн уурын зуухын их засвар (Сүхбаатар)	2015	2015	30.0	30.0
	XIV	ХӨДӨЛМӨРИЙН САЙД			4,000.0	4,000.0
	XIV.1	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэл			4,000.0	4,000.0
	XIV.1.3	III. Тоног төхөөрөмж			4,000.0	4,000.0
		Шинэ			4,000.0	4,000.0
28	XIV.1.3.1	Мэргэжлийн боловсрол, сургалт, үйлдвэрлэлийн төвийн сургалт, дадлагын тоног төхөөрөмж (улсын хэмжээнд)	2015	2015	4,000.0	4,000.0
	XV	ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД			6,400.0	6,400.0
	XV.1.1	I. Хөрөнгө оруулалт			4,400.0	4,400.0
		Шилжих			400.0	400.0
29	XV.1.1.6	Ахмадын сувиллын барилга (Увс, Улаангом)	2012	2015	400.0	400.0
		Шинэ			4,000.0	4,000.0



30	ХҮ.1.1.8	Хараагүй иргэдийн 90 айлын орон сууцны барилга (Улаанбаатар)	2015	2015	4,000.0	4,000.0
	ХҮ.2	Хүүхдийн төлөө үндэсний газар			2,000.0	2,000.0
	ХҮ.2.1	I. Хөрөнгө оруулалт			2,000.0	2,000.0
		Шинэ			2,000.0	2,000.0
31	ХҮ.2.1.3	БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдах "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийн барилга"-ын монголын тал хариуцах гадна шугам сүлжээний зардал, зураг төсөл (Улаанбаатар, Баянгол дүүрэг)	2015	2015	2,000.0	2,000.0
	ХҮI	ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД			42,275.7	14,812.1
	ХҮI.1.1	I. Хөрөнгө оруулалт			15,812.2	2,544.5
		Шилжих			13,313.1	1,000.0
32	ХҮI.1.1.5	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа "Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр-5"	2013	2018	4,613.1	500.0



33	ХҮИ.1.1.7	Бельгийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа “Баруун бүсийн эмчилгээ, оношилгооны төвийг сайжруулах” төсөл	2013	2017	8,700.0	500.0
		Шинэ			2,499.1	1,544.5
34	ХҮИ.1.1.37	Эмнэлгийн барилга (15 ортой), (Говьсүмбэр, Шивээговь сум)	2015	2015	1,110.0	1,110.0
35	ХҮИ.1.1.38	Эрүүл мэндийн нэгдлийг өргөтгөж хүүхдийн эмнэлэг болгох ажлын зураг, төсөв (150 ортой), (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг)	2015	2015	50.0	50.0
36	ХҮИ.1.1.39	Сум дундын нэгдсэн эмнэлгийн барилга (Ховд, Булган сум)	2015	2016	1,339.1	384.5
	ХҮИ.1.2	II. Их засвар			11,334.1	4,867.0
		Шинэ			11,334.1	4,867.0
37	ХҮИ.1.2.1	Харьяа газрын засвар (улсын хэмжээнд)	2015	2016	2,966.7	1,483.3
38	ХҮИ.1.2.2	Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын их засвар (Улаанбаатар)	2015	2016	846.2	423.1
39	ХҮИ.1.2.3	Хүүхдийн эмнэлгийн барилгын засвар (Орхон, Баян-Өндөр сум)	2015	2016	4,000.0	1,200.0



40	ХҮҮ.1.2.4	Аймаг, сумын эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагуудын их засвар (улсын хэмжээнд)	2015	2016	3,521.2	1,760.6
	ХҮҮ.1.3	III.Тоног төхөөрөмж			15,129.4	7,400.5
		Шинэ			15,129.4	7,400.5
		Аймаг, нийслэл			4,741.3	2,748.6
41	ХҮҮ.1.3.3	Аймгуудын Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж (улсын хэмжээнд)	2015	2016	1,050.0	525.0
42	ХҮҮ.1.3.4	Аймгуудын Зооноз өвчин судлалын төв, Уламжлалт анагаах ухааны төвийн тоног төхөөрөмж (улсын хэмжээнд)	2015	2015	406.0	406.0
43	ХҮҮ.1.3.5	Аймгуудын сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж (улсын хэмжээнд)	2015	2016	1,045.3	522.6
44	ХҮҮ.1.3.6	Нийслэл, дүүргүүдийн эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмж (Улаанбаатар)	2015	2016	840.0	420.0
45	ХҮҮ.1.3.7	Аймаг, дүүрэг, сум, өрхийн эмнэлгүүдийг телемедицины сүлжээнд холбох (улсын хэмжээнд)	2015	2015	350.0	350.0



46	ХҮИ.1.3.8	Аймаг, дүүргийн эмнэлгүүдийн эмчилгээний ор хэрэгсэл, шинэчлэл (улсын хэмжээнд)	2015	2016	1,050.0	525.0
		Харьяа байгууллага			10,388.1	4,651.9
47	ХҮИ.1.3.9	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг)	2015	2016	700.0	350.0
48	ХҮИ.1.3.10	Геронтологийн үндэсний төвийн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг)	2015	2015	31.4	31.4
49	ХҮИ.1.3.11	Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг)	2015	2015	175.8	175.8
50	ХҮИ.1.3.12	Эмгэг судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг)	2015	2016	609.6	304.8
51	ХҮИ.1.3.13	Зоонозын өвчин судлалын төвийн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг)	2015	2015	929.8	929.8
52	ХҮИ.1.3.14	Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Баянгол дүүрэг)	2015	2016	1,050.0	525.0



53	ХҮҮ.1.3.15	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг)	2015	2016	700.0	350.0
54	ХҮҮ.1.3.16	Эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн автомашин (улсын хэмжээнд)	2015	2016	3,111.5	770.0
55	ХҮҮ.1.3.17	Эмийн аюулгүй байдлын мэдээллийн системийг сайжруулах (улсын хэмжээнд)	2015	2016	980.0	490.0
56	ХҮҮ.1.3.18	Зүрх судасны тусламж, үйлчилгээний тоног төхөөрөмж (Улаанбаатар, Баянгол дүүрэг)	2015	2016	1,050.0	525.0
57	ХҮҮ.1.3.19	Төв эмнэлгүүдийн эмчилгээний ор хэрэгсэл, багаж шинэчлэл (Улаанбаатар)	2015	2016	1,050.0	200.2
		НИЙТ			182,952.0	52,971.3

Засгийн газрын 2015 оны 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

2015 ОНД ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөгөөр)

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
	ЗАМ ТЭЭВРИЙН САЙД			124,574.2	39,700.0
II.1	I. Хөрөнгө оруулалт			122,874.2	38,000.0



II.1.10	Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан монголын талын гүйцэтгэх төсөл, арга хэмжээ (Төв, Сэргэлэн сум, Хөшигийн хөндий)	2012	2016	122,874.2	38,000.0
II.4	IV. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл			1,700.0	1,700.0
II.4.1	Аймгийн төвөөс хилийн боомтууд чиглэлийн хатуу хучилттай авто замуудын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах (Дорнод, Хэрлэн сум, Баянхошуу боомт, Хавиргын боомт, Ульхан боомт)	2015	2015	1,700.0	1,700.0
	НИЙТ			124,574.2	39,700.0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 2 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

Тооны дээд хязгаар, мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5, 8 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2009 оны 33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2015 онд цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаарыг хавсралт ёсоор баталсугай.

2. Цэргийн дүйцүүлэх албыг 2015 онд мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 4.526.544 (дөрвөн сая таван зуун хорин зургаан мянга таван зуун дөчин дөрвөн) төгрөг байхаар тогтоосугай.



3. Цэргийн албыг дүйцүүлэн хаалгах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Ц.Цолмон, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

Ц.ЦОЛМОН

Засгийн газрын 2015 оны 51 дүгээр
тогтоолын хавсралт

**2015 ОНД ЦЭРГИЙН АЛБЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХААХ
ИРГЭДИЙН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР**

№	Аймаг, нийслэл	Тооны дээд хязгаар
1	Архангай	40
2	Баян-Өлгий	45
3	Баянхонгор	40
4	Булган	35
5	Говь-Алтай	40
6	Говьсүмбэр	10
7	Дархан-Уул	29
8	Дорноговь	14
9	Дорнод	15
10	Дундговь	15
11	Завхан	30
12	Орхон	15
13	Өвөрхангай	55
14	Өмнөговь	40
15	Төв	40
16	Увс	30
17	Сэлэнгэ	30
18	Сүхбаатар	20
19	Ховд	60
20	Хөвсгөл	80
21	Хэнтий	30
22	Улаанбаатар	63
	БҮГД	776



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 2 дугаар
сарын 9-ний өдөр

Дугаар 56

Улаанбаатар
хот

Биеийн тамир, спортын хөгжлийн төв байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа Спортын бэлтгэлийн төвийг Биеийн тамир, спортын хөгжлийн төв болгон өөрчлөн зохион байгуулсугай.

2. Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн орон тооны хязгаар, дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, спортын сайд Г.Шийлэгдамбад даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Спортын бэлтгэлийн төв байгуулах тухай” Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 34 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: tugii_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1

Индекс: 14003